



МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны үр дүнг
дээшлүүлэх талаар гаргасан зөвлөмжийн тухай

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн
хоёрдугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн үйл ажиллагаа болон 2013-2014
онуудын улсын төсвийн санхүүжилт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үйл
ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газрын гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын тайлантай
танилцаж, аудитын хороогоор хэлэлцүүлсэн зөвлөмжийг хавсралтад тусгасанаар
хэрэгжүүлсүгэй.

2. Зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлагын харну арга хэмжээний
төлөвлөгөө боловсруулан, 2015 оны 07 дугаар сарын 01-ны дотор Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Малын удмын сангийн үндэсний төвийн
захирал /Я.Батсүх/-д үүрэг болгосугай.

3. Харну арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч ажиллахыг Хүнс,
хөдөө аж ахуйн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /У.Сауле/-
д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

Р.БУРМАА



МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ТУХАЙ

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 02 дугаар сарын 10 -ны өдрийн удирдамжийн дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, түүний хэрэгжилтийн үр дүнд гүйцэтгэлийн болон санхүүгийн дотоод аудит хийсэн дүгнэлт, зөвлөмж:

НЭГ. МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД:

1. Малын удмын сангийн үндэсний төвийн захирал нь тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу албан хаагчтайгаа үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, үр дүнг дүгнэх;

2. Малын удмын сангийн үндэсний төвийн бүтэц орон тоо, мэргэжилтний ажлын байрны чиглэлийг байгууллагын стратеги, үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан боловсруулж, мэргэжлийн боловсон хүчнээр хангахад анхаарах;

3. Дараах батлагдсан үүлдэр омгийн малын генийн санг хамгаалах, үүлдэрлэг байдлын стандартад заасан ашиг шимийн үзүүлэлтийг бууруулахгүй өсгөн үржүүлэн, сайжруулсан цөм сүргийн малаар нийт үржлийн сүргийг сайжруулахад чиглэсэн стратеги бодлогыг Улс, бүсийн түвшинд боловсруулан, батлуулж мөрдүүлэх;

4. Аймгуудын 12 цөм сүргийн үржлийн төвийн малд ангилалтыг Хүнс, хөдөө аж ахуй яамны Сайдын 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/79 тоот тушаалаар батлагдсан “Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар”-ын дагуу бүрэн ангилж, малын үүлдэрлэг байдлыг тогтоон, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлт хийж, ангилалтын үр дүнг 2015 оны 11 дүгээр сард багтаан Төрийн нарийн бичгийн даргын хурлаар хэлэлцүүлэх;

5. Ангилалт хийсэн үр дүнг тооцон цаашид цөм сүрэгт шаардлагатай хээлтэгч, хээлтүүлэгчийг худалдан авах, ангилалт хийх зардлыг жил бүр улсын төсөвт тусган хэрэгжилтийг холбогдох журам, зааварт нийцүүлэн зохион байгуулах;

6. Малын удмын сангийн үндэсний төвийн үйлдвэрлэл технологийн алба нь үр үйлдвэрлэлийн генийн санг бүрдүүлэх хээлтүүлэгчээс гадна төвийн харьяанд стандартын шаардлага хангасан үржлийн хээлтэгчийг бий болгон, шаардлага хангасан хээлтэгч хээлтүүлэгчийг бойжуулан, цөм сүргийн үржлийн аж ахуй, орон нутгийг хангах арга хэмжээг зохион байгуулах;

7. Төрийн өмчийн цөм сүргийн малын удам гарваль, ашиг шимийн мэдээллийн санг бүрдүүлж дүн, шинжилгээ хийж, үр дүнд тулгуурласан малын үржлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;

8. Малын удмын сангийн үндэсний төв нь цөм сүргийн үржлийн төв, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн боловсон хүчин, тоног төхөөрөмжийг ашиглан цөм

сүргийн үржлийн ажлыг зохион байгуулах, гарсан ололтыг нэвтрүүлэх чиглэлийг баримтлахад түлхүү анхаарч ажиллах;

9. Малын удмын сангийн үндэсний төв, аймгуудын цөм сүргийн үржлийн төвүүд нь үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээг оновчтой төлөвлөх, төсөл боловсруулах, захиалга хэрэгжүүлэх, анхан шатны мэдээ тайлан, акт баримтыг зааврын дагуу үнэн зөв хөтлөхөд анхаарч ажиллах;

10. Дархан-Уул аймгийн Хонгор суманд байгуулж буй “Малын удмын сангийн цогцолбор”-ын барилга байгууламжийг төлөвлөгдсөн зураг төсвийн дагуу гүйцэтгэх үлдэгдэл төсөв болон урсгал зардлыг 2016 оны төсөвт тусган, үйл ажиллагааг нь эхлүүлэх;

11. Малын удмын сангийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулан нягтлан бодох олон улсын стандарт болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийг зохих хууль, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн удирдан зохион байгуулах;

12. Цөм сүргийн аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг сайжруулан нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт үнэн зөв бүрдүүлэхийг салбарын захирал нарт үүрэг болгох, хяналт тавьж ажиллах;

13. Цөм сүргийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан тэнцлийг цөм сүргийн аж ахуй нэгж хариуцсан нягтлан бодогч гаргаж Малын удмын сангийн үндэсний төвийн санхүүгийн тайланд нэгтгүүлэх ажлыг зохион байгуулах;

14. Нярвын бүртгэлийг олон улсын болон улсын секторын нягтлан болох бүртгэлд нийцүүлэн хөтлөн явуулах, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах;

15. Цөм сүргийн салбаруудын өр авлагыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн барагдуулах нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэх;

16. Говь-Алтай аймгийн цөм сүргийн салбарын захирал Ш.Пүрэвзрагчаад хамаарах 2008-2013 оны цалин болох 7.6 сая төгрөгийн асуудал болон бусад аймгуудын цалингийн өглөгт бүртгэгдсэн хэмжээг тус аймгийн Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлсэн актын дагуу шийдвэрлэх;

17. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн өмчийн хорооны 2008 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоол зааснаар Төрийн өмчийн цөм сүргийн малыг үндсэн сүргийн мал, амьтад болон эргэлтийн хөрөнгийн дансанд тус тус ангилан бүртгэх;

18. Аймгуудын Мэргэжлийн хяналтын байцаагч нарын танилцуулгаар бүртгэсэн өглөг, авлагыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нотлох баримтыг үндэслэн залруулах бичилт хийх;

19. Цөм сүргийн малд ангилалт хийж ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийг жил бүр гүйцэтгэсний үндсэн дээр малын орлого, зарлагыг бүртгэх, бүртгэлээс хасах;

20. Дундговь аймгийн цөм сүргийн салбарт хадгалагдаж буй бага оврын тракторыг бусад хэрэгцээтэй байгаа аймгийн цөм сүргийн салбарт данснаас дансанд шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх;

21. Өмнөговь аймгийн цөм сүрэгт ангилалт явуулж, эд хөрөнгөд дахин тооллого хийж дутагдалтай бараа материалыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

22. Малын удмын сангийн үндэсний төвийн 12 аймгийн цөм сүргийн салбаруудын төсвийн орлого, зарлагыг Монгол улсын 2015 оны төсвийн тухай болон Монгол улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудад 12 аймгийн цөм сүргийн салбаруудын төсвийн орлого, зарлагыг тусгах боломжгүй болсон тул тухайн аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудын дарга, нягтлан бодогч нартай тохиролцон тус газрын Төрийн сангийн нэмэлт дансыг ашиглах боломжийг судлан шийдвэрлэх;

23. Дархан-Уул аймгийн Хонгор суманд байгуулагдаж буй “Малын удмын сангийн цогцолбор төв”-ийн үйл ажиллагааны чиг үүргийг төрөөс баримталж буй бодлогын хүрээнд оновчтой тодорхойлон батлуулж, ажиллах мэргэжлийн боловсон хүчин, шаардлагатай багаж төхөөрөмж, стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгч худалдан авах зардлын тооцоог гарган танилцуулж, шийдвэр гаргуулах;

24. Төрийн өмчийн цөм сүргийн үржлийн төвийг Улсын төвийн байгууллага болгон өөрчилж зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлэх асуудлыг судлан танилцуулж, шийдвэрлүүлэх.

ХОЁР: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ

1. Дархан-Уул аймгийн Хонгор суманд байгуулж буй “Малын удмын сангийн цогцолбор”-ын барилга байгууламжийг төлөвлөгдсөн зураг төсвийн дагуу гүйцэтгэх үлдэгдэл төсөв болон урсгал зардлыг 2016 оны төсөвт тусган, үйл ажиллагааг нь эхлүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

2. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, мэргэжлийн болон олон улсын байгууллагуудын хийсэн хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт, салбарын байгууллагуудын бүтэц тогтолцоо, үйл ажиллагаанд үндэслэн ХХААЯ-ны МААБХЗГ, Мал эмнэлэг, үржлийн газрын Мал үржлийн хэлтэс, Малын удмын сангийн үндэсний төв, Аймаг дундын отрын бүсийн захиргаа гэсэн нэгжүүдийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн уялдаа холбоо, давхардлыг хянан мал аж ахуйн салбарын цаашдын хөгжил, удирдлагын зохион байгуулалтын бүтэц, байгууллагуудын мэргэжлийн чиг үүргийг оновчтой болгон өөрчилж, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцад хамаарах мал аж ахуйн салбарын төсвийн байгууллагуудыг нэгтгэх талаар санал боловсруулан сайдад танилцуулан Засгийн газарт өргөн барьж шийдвэрлүүлэх. Үүнд:

- Улсын мал эмнэлгийн газар(Ерөнхий эмч нь улсын байцаагч эрхтэй байх)
- Мал аж ахуйн газар(мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрчимжүүлэх, малын үржил, бэлчээртэй холбогдолтой бүх асуудал, эрчимжсэн мал аж ахуй, малыг эрсдлээс хамгаалах, тэжээлийн хангамж, мал, түүний гаралтай түүхий

эд, бүтээгдэхүүн, маркетинг, бодлого зохицуулалтын асуудлыг хамруулан ойлгох)

3. Дархан-Уул аймгийн Хонгор суманд байгуулагдаж буй “Малын удмын сангийн цогцолбор”- ын үйл ажиллагааг эрхлэх нөхцөлийг хангах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тус байгууламжийн эзэмшлийн газар болон хөрс, усанд Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг 2015 оны төсвөөс гаргах асуудлыг 2015 оны 07 дугаар сарын 01-ний дотор багтаан сайдад танилцуулан шийдвэрлүүлэх;

4. Төрийн өмчийн Цөм сүргийн аж ахуй нэгжүүдийн асуудлыг Төрийн өмчийн хороотой хамтран улсын төсөвт тусгах талаар санал боловсруулан сайдад танилцуулан шийдвэрлүүлэх, төрийн өмчийн цөм сүргийг малын даатгалд хамруулах төсвийг төлөвлөн хэрэгжүүлэх;

5. Төрийн өмчийн цөм сүргийн малын үзлэг, ангилалт, малын даатгалын зардлыг өмнөх онуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнг хянан, холбогдох мэргэжлийн байгууллагуудын санал, үндэслэл, шаардлагыг судлан 2016 оны төсвийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах;

ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ МАЛ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАРТ

1.Төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төвлөрсөн арга хэмжээний болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын 2015 оны А/08 тоот тушаалын 2 дугаар хавсралтад тусгагдсан малд ангилалт хийх, үржилд ашиглах малыг баталгаажуулах зардал болох 200.0 сая төгрөгийг эхний ээлжинд Төрийн өмчийн цөм сүргийн үржлийн аж ахуйн төвийн малыг бүрэн хамруулж, Малын удмын сангийн үндэсний төвд стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийг худалдан авах болон цам сүргийн малын даатгалд зарцуулах;

2. Эрчимжсэн мал аж ахуйд дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгөөр олгосон зээл дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу дэмжлэгийг зарцуулсан байдалд хяналт тавих, зардлыг 2016 оны төсөвт тусгах;

3. Төрийн өмчит цөм сүргийн үржлийн төвийн малд ангилалт хийсэн үр дүнг тооцон цаашид цөм сүрэгт шаардлагатай хээлтэгч, хээлтүүлэгчийг худалдан авах, ангилалт хийх зардлыг жил бүр улсын төсөвт тусган хэрэгжилтийг холбогдох журам, зааварт нийцүүлэн зохион байгуулах;

4. Аймгуудын Төрийн өмчит цөм сүргийн аж ахуйн нэгжүүдийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бие даасан байдлыг хангах, санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх

5. Цөм сүргийн удам гарваль, ашиг шимийн мэдээллийн санг бүрдүүлж дүн шинжилгээ хийж, үр дүнд тулгуурласан малын үржлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;

6. Төрийн өмчийн цөм сүргийн үржлийн төвийг Улсын төсвийн байгууллагын статуст шилжүүлэн, бүтэц орон тоог тогтоон, шаардагдах үндсэн үйл ажиллагааны зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлэх асуудлыг судлан танилцуулж, шийдвэрлүүлэх;

7. Дархан-Уул аймгийн Хонгор суманд байгуулагдаж буй “Малын удмын сангийн цогцолбор төв”-ийн эзэмшлийн газар, хөрс, усны байгаль орчны үнэлгээг хийлгэх асуудлыг 2015 оны 07 дугаар сарын 01-ний дотор багтаан гаргуулан, Сайдын зөвлөлд танилцуулах.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР